



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/67.

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжих Баян-Овоо сумын уурын зуухны худгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	И.Баасанжав	-Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион ажлын хэсгийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА